



“ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР” ТӨРИЙН
ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАРТ

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,
Цахим хуудас: http://www.mof.gov.mn

2024.10.29 № 03/8903
танай _____-ны № _____-т

Гомдол хянасан тухай

Танай байгууллагаас зарласан ЭҮТӨҮГ/202401023 дугаартай “Поддон /хуванцар/” нийлүүлэгчийг сонгох тендер шалгаруулалтад оролцсон “Бурхууд” ХХК-аас гаргасан гомдлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “хууль” гэх)-ийн 59 дүгээр зүйлийн 59.8 дахь хэсэг болон Сангийн сайдын 2023 оны А/253 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам” (цаашид “журам” гэх)-д заасны дагуу захиалагчаас ирүүлсэн холбогдох баримт материалд үндэслэн хянан үзлээ.

“Бурхууд” ХХК-ийн гомдолд захиалагчийн гэрээ байгуулах эрх олгосон “Ай Ти ворлд центр” ХХК-ийн 1 дүгээр маягтад тоогоор болон үсгээр бичсэн үнийн санал зөрүүтэй, барааны үнийн задаргаанд гаалийн татварын 5 хувийг орхигдуулсан, тус компанийн тендерийн үнийг Гаалийн албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татвар ногдуулах хуулийн дагуу тооцоолж үзэхэд 447,120,000 болж өөрчлөгдөх тул хянан үзэхийг хүссэн байна.

Гомдолд дурдсан үндэслэлээр захиалагчийн гэрээ байгуулах эрх олгосон “Ай Ти ворлд центр” ХХК-ийн ирүүлсэн тендерийг хянан үзлээ.

1.Тендер шалгаруулалтын баримт бичгийн тендер шалгаруулалтын зааварчилгааны 14.1-д “IV бүлэг дэх маягтын мэдээллийг хуулийн 21.1.3-т зааснаар цахим системд үүсгэсэн маягтад бөглөж, илгээнэ.” гэж заасны дагуу “Ай Ти ворлд центр” ХХК-аас худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-д ирүүлсэн тендер илгээх 1 дүгээр маягтад бөглөсөн 427,680,000.0 төгрөгийг үнэлгээнд харгалзсан үзсэн захиалагчийн шийдвэр үндэслэлтэй байна.

2.“Ай Ти ворлд центр” ХХК-аас 427,680,000.0 төгрөгийн тендерийн үнэд хамаарах барааны үнийн задаргааны 2 дугаар маягтыг ирүүлснийг хуулийн 27 дугаар зүйлийн 27.13 дахь хэсэгт “Тендер шалгаруулалтын баримт бичигт заасан нөхцөлөөр гэрээний үүрэг гүйцэтгэхэд шаардлагатай татвар, даатгал, тээвэрлэлтийн болон бусад бүх зардлыг тендерийн үнэд багтсан гэж үзнэ.” гэж, тендер шалгаруулалтын баримт бичгийн тендер шалгаруулалтын зааварчилгааны 21.7-д “Үнийн задаргаанд тусгайлан тусгасан эсэхээс үл хамааран тендерийн үнэд хуулийн 27.13-т заасан зардлыг багтсанд тооцно.” гэж заасанд нийцсэн гэж хянан үзсэн захиалагчийн шийдвэр үндэслэлтэй байна.

9766016719

“Ай Ти ворлд центр” ХХК-ийн барааны үнийн задаргаанд гаалийн албан татвар тооцогдоогүй тухай гомдол үндэслэлгүй байна.

Иймд тендер шалгаруулалтыг хуульд заасан журмын дагуу цааш үргэлжлүүлэх нь зүйтэй байна.

Хуулийн 59 дүгээр зүйлийн 59.7 дахь хэсэгт заасны дагуу захиалагчийн шийдвэр буюу үйлдлийн хэрэгжилтийг түдгэлзүүлсэн шийдвэрийн хугацаа үүгээр дуусгавар болно.

Хувийг: “Бурхууд” ХХК-д.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА



Ж. ГАНБАТ